



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн ажилтнуудын төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн хорооноос 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр гаргасан гомдол, хүсэлтэд дурдсан асуудлыг судалж тогтоох үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч	Д.Дэлгэрмаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүд:	В.Дарханбаатар	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга
	Д.Будхүү	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Мэдээлэл, технологийн албаны дарга
	Б.Янжинлхам	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Цэрэнлхам	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Д.Дариймаа	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 14-ний өдрийн хооронд “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанид энэ тушаалын хавсралтад заасан удирдамжийн дагуу ажиллаж, тайланг 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Дэлгэрмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨБЗГ тушаал-/2023

132003128

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын
11-ний өдрийн *А/28* дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Ажлын хэсэг нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. "Цемент шохой" ТӨХК-ийн үйлдвэрийн бэлэн байдалтай танилцаж, чулуунцрын аюулгүйн нөөц бүрдүүлэлт зохих хэмжээнд байгаа эсэхийг шалгах;
2. "Цемент шохой" ТӨХК-ийн 2022 оны 04 дүгээр сараас хойших хүний нөөцийн чиглэлээр гаргасан Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэртэй танилцаж, хууль зүйн үндэслэлийг хянах;
3. Компанийн цалин хөлсний дүрэм журамтай танилцаж, дүгнэлт гаргах.

-----oOo-----

БАТЛАВ.
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ


ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

Сэлэнгэ аймагт “Цемент шохой” ТӨХК-ийн ажилтнуудын төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн хорооноос гаргасан гомдол, хүсэлтэд дурдсан асуудлыг судалж тогтоох үүрэг бүхий Ажлын хэсэгт орж ажиллаж байгаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Мэдээлэл, технологийн албаны дарга Д.Будхүү, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Янжинлхам, Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Д.Цэрэнлхам, Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Дариймаа, жолооч Х.Базаррагчаа нарын албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: Ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдрөөс 04 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал ажлын /хуанлийн 4 хоногийн/ хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/	Хянасан (төгрөгөөр)
1	2	3	4
1	Унааны зардал: Сэлэнгэ аймаг Хөтөл тосгон явах ирэх унааны зардал 960 км х 2390 х 0,25 =573,600	573,600.00	
2	Байр: 7 хүн х 4 хоног х 110,000 =3,080,000 Хоол: 7 хүн х 4 хоног х 32,000 =896,000	3,976,000.00	
	Нийт дүн:	4,549,600.00	

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дүгээр тушаалаар баталсан “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалыг үндэслэв.

Танилцаж зөвшөөрсөн:  Н.Ганболд /Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/

Төсөв хянасан:  Д.Отгонтуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Зардлын төсөв боловсруулсан:  Г.Туул /ЗУХ ахлах мэргэжилтэн /